

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/71/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Дархан-Уул аймаг 2026 он	Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
	Аудитор: Ч.Гантулга Утас: 99372297 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 122  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 6,455.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж болон 18,270.0 мянган төгрөгийн 9 ш компьютерийг тус тус хүлээн авч, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны А/36 тоот тушаалын дагуу бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 232,145.1 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 22 хувиар өссөн байна.

4526050081

## Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 96 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>163,203,509.15</b>	<b>71,604,734.32</b>
<b>31</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>142,964,158.43</b>	<b>26,446,180.40</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа</b>	<b>142,964,158.43</b>	<b>26,446,180.40</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	142,964,158.43	26,446,180.40
31211	Төрийн сангийн харилцах	142,964,158.43	26,446,180.40
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>20,239,350.72</b>	<b>45,158,553.92</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>20,239,350.72</b>	<b>45,158,553.92</b>
35410	Бичиг хэргийн материал	501,480.00	101,700.00
35420	Аж ахуйн материал	18,061,723.92	35,125,840.92
35460	Хүнсний материал	1,676,146.80	9,931,013.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>895,210,875.34</b>	<b>956,334,477.40</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>895,210,875.34</b>	<b>956,334,477.40</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгийн дүн</b>	<b>772,276,875.34</b>	<b>833,400,477.40</b>
39201	Барилга байгууламж	744,618,440.00	744,618,440.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(68,348,517.60)	(84,377,587.32)
39205	Машин тоног төхөөрөмж	66,776,383.00	95,653,683.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,541,924.53)	(26,685,333.38)
39207	Тавилга, эд хогшил	32,661,561.50	22,007,483.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,251,830.52)	(11,366,807.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	86,684,420.00	86,644,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(53,865,926.51)	(63,150,989.99)
39217	Ном	544,270.00	544,270.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>122,934,000.00</b>	<b>122,934,000.00</b>
39301	Программ хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хасагдуулга	(1,124,300.00)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	122,934,000.00	122,934,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,058,414,384.49</b>	<b>1,027,939,211.72</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,058,414,384.49</b>	<b>1,027,939,211.72</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,058,414,384.49</b>	<b>1,027,939,211.72</b>
511	Засгийн газрын оруулсан капитал	122,934,000.00	122,934,000.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>935,480,384.49</b>	<b>735,504,799.71</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	935,480,384.49	835,492,592.10
51220	Тайлант үеийн үр дүн	-	(99,987,792.39)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,058,414,384.49</b>	<b>1,027,939,211.72</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>903,040,900.00</b>	<b>958,259,973.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>22,298,500.00</b>	<b>70,875,773.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>22,298,500.00</b>	<b>70,875,773.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	21,748,500.00	34,161,873.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	550,000.00	36,713,900.00
13	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>880,742,400.00</b>	<b>887,384,200.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>831,243,500.00</b>	<b>844,057,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	831,243,500.00	844,057,200.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>49,498,900.00</b>	<b>43,327,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,498,900.00	43,327,000.00
2	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>881,072,643.99</b>	<b>1,052,591,011.71</b>
21	<b>Урсгал зардал</b>	<b>881,072,643.99</b>	<b>1,052,591,011.71</b>
210	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>860,893,785.18</b>	<b>1,045,766,050.17</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>589,538,512.38</b>	<b>743,525,934.83</b>
210101	Үндсэн цалин	408,087,122.06	499,213,435.08
210102	Нэмэгдэл цалин	153,674,841.59	183,708,589.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	30,432,000.00
210104	Урамшуулал	27,776,548.73	30,171,910.00
2102	<b>Нийгмийн даатгалын шимтгэл</b>	<b>77,853,680.19</b>	<b>90,119,633.20</b>
210201	Тэтгэврийн даатгалын	54,907,910.30	60,131,533.20
210202	тэтгэмжийн даатгалын	5,994,072.58	7,497,100.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,891,486.43	3,748,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	2,812,041.72	3,748,500.00
210205	ЭМ-ийн даатгалын	11,248,169.16	14,994,000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,686,341.19</b>	<b>26,502,038.46</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	7,642,243.87	10,037,851.65
210302	Түлш, халаалтын зардал	9,965,479.44	8,690,555.01
210303	Цэвэр бохир усны зардал	6,078,617.88	7,773,631.80
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,256,883.74</b>	<b>11,810,363.00</b>
210401	Бичиг хэргийн зардал	10,854,145.60	3,014,440.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	284,880.00	885,340.00
	Бараа материал акталсны зардал	7,117,858.14	7,910,583.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>80,059,427.10</b>	<b>86,985,643.80</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	293,000.00	150,000.00
210502	Хоол, хүнс	79,766,427.10	86,835,643.80
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,219,600.00</b>	<b>25,159,200.00</b>
210604	Урсгал засварын зардал	22,219,600.00	25,159,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс</b>	<b>2,055,200.00</b>	<b>4,846,000.00</b>
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,055,200.00	4,846,000.00
2109	<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>47,224,140.58</b>	<b>56,817,236.88</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>985,906,741.00</b>	<b>887,384,200.00</b>
13	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>985,906,741.00</b>	<b>887,384,200.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>936,407,841.00</b>	<b>844,057,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	936,407,841.00	844,057,200.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>49,498,900.00</b>	<b>43,327,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,498,900.00	43,327,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>835,980,682.57</b>	<b>1,002,522,278.03</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>835,980,682.57</b>	<b>1,002,522,278.03</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>815,801,823.76</b>	<b>995,697,316.49</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>589,538,512.38</b>	<b>743,525,934.83</b>
210101	Үндсэн цалин	408,087,122.06	499,213,435.08
210102	Нэмэгдэл	153,674,841.59	182,119,541.96
210103	Хоол унаа хөнгөлөлт	-	30,172,536.52
210104	Урамшуулал	27,776,548.73	32,020,421.27
2102	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>77,853,680.19</b>	<b>90,119,633.20</b>
210201	Тэтгэврийн даатгалын	54,907,910.30	60,131,533.20
210202	Тэтгэмжийн даатгалын	5,994,072.58	7,497,100.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,891,486.43	3,748,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	2,812,041.72	3,748,500.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	11,248,169.16	14,994,000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,686,341.19</b>	<b>26,502,038.46</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	7,642,243.87	10,037,851.65
210302	Түлш, халаалтын зардал	9,965,479.44	8,690,555.01
210303	Цэвэр бохир усны зардал	6,078,617.88	7,773,631.80
2105	<b>Нормативт зардал</b>	<b>72,575,240.00</b>	<b>95,090,510.00</b>
210502	Хоол, хүнс	72,575,240.00	95,090,510.00
2106	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>22,499,600.00</b>	<b>10,000,000.00</b>
210604	Урсгал засвар	22,499,600.00	10,000,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,150,600.00</b>	<b>-</b>
		1,150,600.00	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,555,200.00</b>	<b>4,821,000.00</b>
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,555,200.00	4,821,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,942,650.00</b>	<b>25,638,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,514,400.00	16,995,100.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	8,428,250.00	8,643,100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,178,858.81</b>	<b>6,824,961.54</b>
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	16,865,900.00	-
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,312,958.81</b>	<b>6,824,961.54</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,312,958.81	6,824,961.54
3	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>149,926,058.43</b>	<b>(115,138,078.03)</b>
5	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	<b>15,038,800.00</b>	<b>1,380,000.00</b>
22	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>23,115,700.00</b>	<b>1,380,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>23,115,700.00</b>	<b>1,380,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	6,961,900.00	1,380,000.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,381,000.00	9,899,200.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	8,643,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,843,140.58	38,274,136.88
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>20,178,858.81</b>	<b>6,824,961.54</b>
	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	16,865,900.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,312,958.81</b>	<b>6,824,961.54</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,312,958.81	6,824,961.54
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>21,968,256.01</b>	<b>(94,331,038.71)</b>
<b>225</b>	<b>Үйл ажиллагааны бус зардлын дүн</b>		<b>(5,656,753.68)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>(5,656,753.68)</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		(5,656,753.68)
<b>4</b>	<b>Үйл ажиллагааны бус үр дүн</b>	-	5,656,753.68
<b>5</b>	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>21,968,256.01</b>	<b>(99,987,792.39)</b>

6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(6,961,900.00)	(1,380,000.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	142,964,158.43	(115,138,078.03)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	142,964,158.43
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	142,964,158.43	26,446,180.40

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
A	1	2	3	4
<b>2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>122,934,000.00</b>	-	<b>935,480,384.49</b>	<b>1,158,402,176.88</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		-	-	-
ҮХ-ийн есөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний есөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(99,987,792.39)	(99,987,792.39)
<b>2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>122,934,000.00</b>	-	<b>935,480,384.49</b>	<b>1,058,414,384.49</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
ҮХ-ийн есөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(99,987,792.39)	-
<b>2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>122,934,000.00</b>	-	<b>835,492,592.10</b>	<b>1,058,414,384.49</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	887,384,600.00	880,559,238.46	(6,825,361.54)	99.23
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	844,057,600.00	844,057,200.00	(400.00)	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	844,057,600.00	844,057,200.00	(400.00)	100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,327,000.00	36,502,038.46	(6,824,961.54)	84.25
132001	Орон нутгийн төсвөөс	43,327,000.00	36,502,038.46	(6,824,961.54)	84.25
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	142,964,158.43	-	(142,964,158.43)	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	142,964,158.43	-	(142,964,158.43)	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,030,348,758.43	880,559,238.46	(149,789,519.97)	85.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,028,553,800.00	997,077,216.49	(31,476,583.51)	96.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,028,553,800.00	997,077,216.49	(31,476,583.51)	96.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	747,346,600.00	743,525,934.83	(3,820,665.17)	99.49
210101	Үндсэн цалин	506,792,900.00	499,213,435.08	(7,579,464.92)	98.5
210102	Нэмэгдэл	220,499,800.00	182,119,541.96	(38,380,258.04)	82.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	30,172,536.52	30,172,536.52	-
210104	Урамшуулал	20,053,900.00	32,020,421.27	11,966,521.27	159.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,237,300.00	90,119,633.20	(3,117,666.80)	96.66
210201	Тэтгэврийн даатгал	63,249,300.00	60,131,533.20	(3,117,766.80)	95.07
210202	Тэтгэмжийн даатгал	7,497,000.00	7,497,100.00	100.00	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,748,500.00	3,748,500.00	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	3,748,500.00	3,748,500.00	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	14,994,000.00	14,994,000.00	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,046,400.00	26,502,038.46	(21,544,361.54)	55.16
210301	Гэрэл, цахилгаан	16,350,600.00	10,037,851.65	(6,312,748.35)	61.39
210302	Түлш, халаалт	19,337,400.00	8,690,555.01	(10,646,844.99)	44.94
210303	Цэвэр, бохир ус	12,358,400.00	7,773,631.80	(4,584,768.20)	62.9
2105	Нормативт зардал	97,654,000.00	95,090,510.00	(2,563,490.00)	97.37
210502	Хоол, хүнс	97,654,000.00	95,090,510.00	(2,563,490.00)	97.37
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,821,100.00	4,821,000.00	(100.00)	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,821,100.00	4,821,000.00	(100.00)	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,448,400.00	27,018,100.00	(430,300.00)	98.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,805,300.00	18,375,100.00	(430,200.00)	97.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,643,100.00	8,643,000.00	(100.00)	100
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,028,553,800.00	997,077,216.49	(31,476,583.51)	96.94
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	142,964,158.43	142,964,158.43	-

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		26,446,180.40	26,446,180.40	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1		(1.00)	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	60	59	(1.00)	98.33
6	Удирдах ажилтан	2	2	-	100
7	Гүйцэтгэх ажилтан	34	33	(1.00)	97.06
8	Үйлчлэх ажилтан	24	24	-	100

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 3,088.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг 100 хувийн хэрэгжилттэй байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-	100
Албан шаардлага	1	3,088.0	1	3,088.0	
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>3,088.0</b>	<b>2</b>	<b>3,088.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,133.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд төсвийг хохиролгүй болгох 837.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийн давтан гаргахгүй 7,296.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэв.

#### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1. Илрүүлэлт:** Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч А.Соёлмаагийн сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"-ын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар"-ын 3-д "Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

**5.1.2. Илрүүлэлт:** Тус цэцэрлэгийн эрхлэгч А.Соёлмаад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг олгоогүйгээс нийт 237.6 мянган төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

зориулалтын дагуу зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Ажил олгогч нь ажилтантай тохиролцооноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно”, 56.2-д “Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

## 5.2 Албан шаардлага

**5.2.1.Илрүүлэлт:** Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч А.Соёлмаа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,619.2 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, **хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна**”, 27.6-д “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт “Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг **аль нэг ажилтанд хавсран хариуцуулна**. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

**5.2.2.Илрүүлэлт:** Тус цэцэрлэгийн нягтлан бодогч Б.Балжиннямд Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “өөрчлөлтгүй” дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 3 дахин нэмэгдүүлж, 4,677.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-д “Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай”, “Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.8-д “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

## 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч А.Соёлмаагийн сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	-	-
Тус цэцэрлэгийн эрхлэгч А.Соёлмаад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг олгоогүйгээс нийт 237,600.00 төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	237.6	1	237.6	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч А.Соёлмаа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,619,200.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	1	2,619.2	-	-	1	2,619.2	-	-	-	-	-	-
Тус цэцэрлэгийн няглан бодогч Б.Балжиннямд Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн Б/36 дугаар тушаалыг тус	1	4,677.0	-	-	1	4,677.0	-	-	-	-	-	-





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 48/02

Дархан сум

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус цэцэрлэгийн эрхлэгч А.Соёлмаад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг олгоогүйгээс нийт 237,600.00 төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно", 56.2-д "Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагналыг урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Илүү тооцож олгосон 237,600.00 (хоёр зуун гучин долоо мянга зургаан зуун) төгрөгийг эрхлэгч А.Соёлмаагаар төлүүлж, Төрийн сан банкин дахь Да.Хүү, торгуулийн орлогын MN330090100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч А.Соёлмаа, нягтлан бодогч Б.Балжинням нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.ЦЭРЭННАДМИД

"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Ч.ГАНТУЛГА

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

4525110214



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 42/01

Дархан сум

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч А.Соёлмаагийн сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"-ын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар"-ын 3-д "Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Сургалтын төлбөрт төлсөн 600,000.00 (зургаан зуун мянган) төгрөгийг эрхлэгч А.Соёлмаагаар төлүүлж Төрийн сан банкин дахь Да.Хүү, торгуулийн орлогын MN330090100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч А.Соёлмаа, нягтлан бодогч Б.Балжинням нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

"ЦЭСБ АУДИТ "ХХК-ИЙН ЗАХИРАЛ

"ЦЭСБ АУДИТ "ХХК-ИЙН АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЦЭРЭННАДМИД

Ч.ГАНТУЛГА

Ш.МӨНХБАЯР

4525110210



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 он 02 сар 24 өдөр

Дугаар 58/02

Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус цэцэрлэгийн нягтлан бодогч Б.Балжиннямд Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн Б/36 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 3 дахин нэмэгдүүлж, 4,677,000.00 төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-д "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Төсвийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч А.Соёлмаа, нягтлан бодогч Б.Балжинням нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.ЦЭРЭННАДМИД

"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Ч.ГАНТУЛГА

БАТАЛГААЖУУРСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

4526090320



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐26 он 02 сар ᠒᠕ өдөр

Дугаар ᠑᠕/᠐1

Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймгийн Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч А.Соёлмаа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,619,200.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын **үйл ажиллагааг удирдах**", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, **хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна**", 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг **аль нэг ажилтанд хавсран хариуцуулна**. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Төсвийн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан сумын 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч А.Соёлмаа, нягтлан бодогч Б.Балжинням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.ЦЭРЭННАДМИД

"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Ч.ГАНТУЛГА

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



᠕᠑᠑᠐90313